

Тээврийн салбарын мэргэжлийн үг үүсэх аргын тухай

*Хөөдөөгийн ГЭНДЭНПИЛ***Монгол Улс, Улаанбаатар**Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн,**Хэрэглээний хэл шинжлэлийн салбар;**Монгол Улсын Боловсролын Их Сургууль,**Монгол хэлний тэнхимийн докторант***Received:** September 15, 2025 | **Accepted:** November 15, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд тээврийн салбараар тоймлон, монгол хэлний мэргэжлийн үг үүсэх арга, зүй тогтлыг авч үзэв. Тээврийн салбар, тэр дундаа зам тээврийн салбарын мэргэжлийн үгс авиа зүйн болон адилтгалын аргаар, мөн этгээд үг, хэлц үгийн хэв маягаар үүсэж байна. Мэргэжлийн үг нь нэр томьёо, утга зохиолын хэлний үг хоёрын дунд зуучийн үүрэгтэй, завсрын шинжтэй тул нэр томьёо оноох бүрэн боломжтой. Тухайн ойлголт, ухагдахууныг шинж чанараар нь илэрхийлсэн хэлц нэр томьёотой адил хэлц мэргэжлийн үг олонтоо тохиолдож байна. Мөн этгээд үг хэллэг нь мэргэжлийн үгэнд хамаарах бөгөөд хэл яриаг хөхиүн хөгжүүн болгох, хэлний дохиог товч, оновчтой цомхон илэрхийлэх зэрэг ач холбогдолтой юм. Ийнхүү мэргэжлийн үг, мэргэжлийн этгээд үг, нэр томьёо нь мэргэжлийн хэлийг бүрдүүлнэ.

Түлхүүр үг: мэргэжлийн хэл, мэргэжлийн үг, нэр томьёо, адилтгалын арга, хэлц үг, этгээд үг

* © Х.Гэндэнпил, 2025

Email: gendenpil_kh@mas.ac.mn,  orcid.org/0009-0008-2748-9789



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

On the Issues Creating Methods of Transportation Professionalism

GENDENPIL Khuuduu

Department of Applied Linguistics,
the Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences;
Doctorate Student of Department of Mongolian Language and Linguistics,
School of Arts and Sciences, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: The article deals with the formation of professional words in the transport sector and examines the methods in Mongolian language. Professional words in the transport sector particularly in road transport are formed through phonological processes and analogy, as well as through the use of jargon and idiomatic expressions. Professional words serve an intermediary function between terminology and literary language vocabulary, possessing transitional characteristics; therefore, they have full potential to develop into formal terms. Idiomatic specialized expressions that convey concepts and notions through their defining features, similar to terminological phrases, are frequently encountered. In addition, jargon is considered part of professional words and plays an important role in making speech more vivid and expressive, as well as in conveying linguistic signals concisely and precisely. There through professional language consists of professional words, professional jargon, and terminology.

Keywords: special language, professional words, terms, metaphorical method, phrases, jargon

1. Удиртгал

Хэлийг хам болон цуваа цагийн үүднээс хөдлөнгө болон зогсонги хоёр талаас нь судлах нь зохистой. Хэл зүй түүхэн тодорхой цаг үед тогтонги хэв шинжтэй бол үгийн сан хөгжил, хөдөлгөөнд оршдог хөдлөнгө хэв шинжтэй юм. Нэр томьёо, мэргэжлийн үгс үгийн сангийн найрлага бүрэлдэхүүнд хамаарна. “Монгол хэлний үгийн сангийн үүсвэр бүрэлдэхүүнийг уугуул үг, харь үг гэж ангилах бөгөөд найрлага бүрэлдэхүүнийг *бичгийн* болон *ярианы* үг, *хуучин* болон *шинэ* үг, *нэр томьёо* болон *мэргэжлийн* үг, *этгээд* болон *бүдүүлэг* үг, *цээрлэсэн* болон *ээрүүлсэн* үг, *хүндэтгэлийн* болон *доромж* үг гэж ангилдаг” (Шагдарсүрэн ба бус, 2022: 27-116). “Нэр томьёотой туйлын ойролцоо зүйлийн нэг нь мэргэжлийн үг хэллэг (профессионализм). Энэ нь аль нэгэн хөдөлмөрийн хуваарьтай холбон хэрэглэгдсээр ирсэн. Мэргэжлийн үгийг ихэвчлэн өөр өөр төрлийн мэргэжлийн хүн мэддэг бөгөөд нэр томьёотой харьцуулбал энгийн хялбар байдлаар урсгалаараа зохиогдсон байдаг (Төмөрцэрэн, 2023: 94). Ж. Надмид, Ц.Өнөрбаян нар “мэргэжлийн үг гэдэг нь нэр томьёо, нийт утга зохиолын хэлний үгс хоёрын завсрын шинжтэй үгс юм. Нэр томьёо бол шинжлэх

ухааны ямар нэг ухагдахууныг оновчтой үг, холбоо үгээр зориуд тэмдэглэсэн, тухайн мэргэжлийн хүмүүст ойлгомжтой, тэр мэргэжлийн хүрээнд хэрэглэдэг үгс” (Надмид, Өнөрбаян, 2023: 159) хэмээн завсрын шинжтэй үг гэж тодорхойлжээ. Н.Нансалмаа “ажил мэргэжил нэгтэй хүмүүс зөвхөн тэдний өөрсдийн хүрээнд хэрэглэж заншсан юм, үйл явц, хөдөлмөрийн үр дүнг нэрлэх үгтэй байдаг. Ийм үг хэллэгүүдийг мэргэжлийн үг хэллэг гэж нэрлэнэ. Мэргэжлийн үг хэллэг нь голдуу нэр томьёотой ойролцоо утгын харьцаанд орох үг хэллэг” (Шинэбаяр, 2024: 31) гэжээ. Тусгай салбар, мэргэжлийн хүрээнд хамаарах үг хэллэгийг мэргэжлийн үг гэдэг бөгөөд тусгай онохууны талбар болон мэргэжлийн салбарт хэрэглэдэг байгаж хэл*-ний цогцыг мэргэжлийн хэл (Мөнхцэцэг ба бус, 2024: 35) гэнэ. Нэр томьёо шинжлэх ухааны тусгай салбарын ухагдахууныг нэрлэн томьёолох бол мэргэжлийн үг энгийн хялбар байдлаар урсгалаараа зохиогдсон байдаг. Нэр томьёог “оноох, тогтоох” гэдэг бол мэргэжлийн үг “үүсэх” гэдэг нь гол ялгаа юм.

Мэргэжлийн үгийн нэр томьёоны тухайд мэргэжлийн хэллэг (professionalism, профессионализм) (Төмөртоого, 2004: 99), мэргэжлийн үг, хэллэг (professionalism, профессионализм) (Зэнямбуу, Базаррагчаа, 2014: 163) гэж зөрөөтэй томьёолж ирсэн ба мэргэжлийн үг (professional words) гэвэл илүү оновчтой юм.

2. Судалгааны арга зүй

Бид нутгийн аялгуу, аман зохиол судлал, угсаатан судлал, нийгэм хэл шинжлэлийн судалгаанд хэрэглэдэг асуулга (нээлттэй асуулга) болон ярилцлагын аргаар тээврийн хэрэгсэл, түүний эд ангид хамаарах мэргэжлийн үгийн сан (300 үг, үг хэллэг) бүрдүүлэв. Мөн *Улсын нэр томьёоны комиссын мэдээ* сэтгүүлийн 21, 52, 117-118, 134-135, 140-143 дугаарыг дагалдах хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Асуулга, ярилцлагад хүнд машин механизмын 10 жолооч (Ховд аймгийн Цэцэг сумын Хөшөөтийн уурхайн Мо Эн Ко хувьцаат компани) хамрагдсан. Зам тээврийн салбарын мэргэжлийн үг нь авиа зүйн болон адилтгалын аргаас гадна этгээд үг болон хэлц үгийн хэв маягаар үүсэж байна. Адилтгалын аргаар болон этгээд үг, хэлц үгийн хэв маягаар үүссэн үгсийг үндэсний сэтгэлгээний онцлог, танин мэдэх хэв шинжтэй холбон судлав. Авиа зүйн аргаар үүссэн үгс нь харь хэлний үгийг өгүүлэх, авиалах, нутагшуулах тухай асуудал юм.

3. Жолооч нарын мэргэжлийн үгс

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн нэр томьёоны тодорхойлолтод “тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүн”-ийг жолооч**

* Байгаж хэл (en. natural language, ru. естественный язык) гэдэг нь цахим орчин, хиймэл оюун ухаан болон технологийн бусад хэлбэрт хувираагүй зохиомол бус хүний хэлийг хэлнэ. Байгаж гэдэг нь хэзээнээс байсан, угийн, байгалийн, заяагдмал шинж чанар гэсэн утгатай. Өвөр Монголын өөртөө засах оронд байгаж яриа хэмээн тусгайлан судалж байгаа билээ.

** <https://legalinfo.mn/mn/detail/11224>

гэж тодорхойлжээ. Мэргэжлийн явцуу хүрээний үгийн сан, ажил мэргэжлийн үг, этгээд үг хэллэгийг хэрэглэгч бүлэг хүмүүс тусгай хэлний хамтлаг (specific language community) (Мөнхцэцэг ба бус, 2024: 91)-ийг бүрдүүлнэ. Жолооч нь албан ёсны мэргэжил тул тусгай хэлний хамтлаг, хам орчин юм. Иймд жолооч нарын харилцаанд тохиолдох мэргэжлийн үгийг тээврийн хэрэгсэл болоод эд анги гэсэн хоёр чиглэл болгон судлах нь зохилтой юм.

Машин техник болон тээвэрлэлттэй холбоотой нэр томьёо, мэргэжлийн үгийг “Улсын нэр томьёоны комиссын мэдээ” цувралаар эрхлэн гаргаж байв. Тухайлбал,

- Орон сууц, нийтийн аж ахуйн техник УНТКМ № 117-118 (1982);
- Техник УНТКМ № 21 (1954);
- Хөдөө аж ахуйн техник УНТКМ № 52 (1963);
- Хөдөө аж ахуйн машин техник УНТКМ № 134-135 (1985);
- Шварц, В.В. Машин техникийн зурагт орос англи монгол товч толь УНТКМ № 140-143 (1988) г.м

Эдгээр нь машин техник, түүний эд ангид хамаарах нэр томьёо юм. Энэхүү нэр томьёоны цуврал бичгүүдэд ардын амьд ярианы хэлэнд бий болсон мэргэжлийн үгээр нэр томьёо оноосон нь олонтоо тохиолдоно. Бид мэргэжлийн үгийг авиа зүй болон адилтгалын аргаар үүссэн, этгээд болон хэлц үгийн шинжтэй хэмээн ангилж үзэв.

3.1. Авиа зүйн арга

Хүний хэл анх байгаль дэлхий, араатан амьтдын авиаг дуурайн оролдож байснаас үүссэн гэж үздэг онолыг “аялга үгийн онол” (Батчулуун, 2016: 272) гэдэг. Монгол хэлэнд үгийн сангийн тодорхой утгагүй давталтын аргаар үүссэн дуу авиа дуурайх *над над* хэмээх үг бий. Ийнхүү жижиг оврын тракторыг *над над* гэсэн нь дуу авиагаар нь төлөөлүүлж, шинэ нэрлэлт үүсгэсэн хэрэг юм.

Тээврийн хэрэгслийн эд ангийг ярианы хэлэнд *стартер* → *астаачир* [astʰa:ʃʰir], *радиотор* → *аржаатар* [arʃa:tʰar], *амартизатор* → *амаржийн* [amarʃi:n], *сигнал* → *чигнаал* [ʃʰikna:l], *кузов* → *гүүзүү* [ku:tsu:], *тапиал* → *маниул* [mæno:l], *крыло* → *хирлаа* [xirɫa:], *трансформатор* → *таран бүлүүр* [tʰharan puɮu:r] хэмээн монгол хэлний авианы дуудлагаар нутагшуулсан нь бий. Таслан хуваарилах үүрэгтэй трансформаторыг *таран бүлүүр* хэмээн орос монгол холимог үгээр нутагшуулжээ. Энэ нь мэргэжлийн үг авиа зүйн аргаар үүсэж буй үзэгдэл юм.

“Латин хэлнээс гаралтай *signum* буюу герман хэлний *signal* хэмээх үг нь монгол хэлнээ *чагнаал* (сигнал) гэж дуудагдах боловч монгол хүний сэтгэхүйд *ᠴi-ng-na* (чагнах) гэдэг үгтэй гарал нэг мэт бодогддог байна. Гэвч үүнд *si-ng, ta-ng, ᠴi-ng* гэх мэт авиа дуурайх үгсийн ул мөр нуугдаж байгааг үгүйсгэх аргагүй юм. Хэлний аваргас бүтэц (macrostructure) хэл хоорондын хэлбэрээрээ ижилсэх үзэгдлийн онолоор гарал судлалын олон асуудлыг шийдэж болно” (Идэрбаяр, 2005: 26). Үүнд хамаарах *астаачир* [astʰa:ʃʰir] хэмээх бэлээхэн жишээ бий.

Орос хэлнээс монгол хэлнээ нэвтэрсэн *стадион* [istʰatʰion], *студень* [istʰu:ʃin], *стандарт* [istʰantʰa:rtʰ], *стратегия* [istʰratʰhe:k] зэрэг үгийн дуудлагаас харахад тэргүүн үед “а” авиалбаргүй дуудагдах агаад *стартер* → *астаачир* [astʰha:ʃʰir] болж ондоошсон нь *асаа* *асаах* “асаах” гэдэг үйл үгийн тэргүүн үе-утгалбартай хэлбэрээрээ ижилсэж буй үзэгдэл юм. Энэ нь стартерын үндсэн үүрэг асаах тул *астаачир* болж ондоошжээ.

3.2. Адилтгалын арга

Монгол хэлэнд *аавын цээж* (УАЗ), *ээжийн бөгс* ~ *араг үүрсэн чавганц* (москвич), *золбин шар** (такси), *нисдэг авс* (микробус), *шаахайт* (3 дугуйт) зэрэг этгээд үг хэллэг арвин тохиолдож байв. Энэ нь тухайн эд юм ухагдахууны хэрэглээ буурсан тул түүхэн үгийн шинжтэй болж байна. Харин орчин цагийн монгол хэлэнд *авгалдай* (ZM12), *унагалдай* (бага оврын эксковатор), *амьжиргаа цагаан* (Kei truck хэмээх 350-400 килограммын даацтай жижиг оврын ачааны автомашин), *чарга* (пробокс), *пад пад* (жижиг оврын трактор) зэрэг тээврийн хэрэгслийн нэр бүхий мэргэжлийн болон этгээд үг хэллэгийг идэвхтэй хэрэглэж байна. Тээврийн хэрэгслээс гадна *шалдан мотор* (дагалдах эд ангигүй мотор), *мэлхий араа* (тракторын хүнд араа), *туулай араа* (тракторын хөнгөн араа), *зүрх араа* (гол араа), *хацар араа* (зүрх арааны дэргэдэх араа) зэрэг эд ангийг илтгэсэн мэргэжлийн үгс тохиолдох ба гол төлөв адилтгалын аргаар үүсжээ. “Мэргэжлийн үг нь гарал үүслийн хувьд өдөр тутмын хэрэглээний үгийн сангийн утгыг зүйрлэл байдлаар хувиргасны үр дүн юм” (Шагдарсүрэн ба бус, 2022: 106).

Нэр томьёо, мэргэжлийн үгс мэргэжлийн хэлийг бүрдүүлнэ. Шинжлэх ухааны хэлийг хөгжүүлэхэд ярианы хэлнээ буй тухайн мэргэжлийн үг, хар ярианы үг хэллэг, хэлц; ажил хөдөлмөртөө хэрэглэж ирсэн, бичгийн ном зохиолд тусгасан мэргэжлийн үг хэллэг буюу нэр томьёоны шинжтэй ардын уламжлалт үг хэллэг, орчин үеийн мэргэжлийн үг хэллэг чухал үүрэгтэй (Шинэбаяр, 2024).



Зураг 1. Авгалдай

Эх сурвалж: <https://westsidetractorsales.com/>



Зураг 2. Унагалдай

Эх сурвалж: <https://www.directindustry.com/>

* Англи хэлний scooter “скүүтер” хэмээх үгийг золбин хөх, гүймэг хөх хэмээн оноож ч болох билээ.

Ж.Баянсан “тухайн үгийн утгыг хийсвэрлэн ондоошуулж, өөр юмны нэрлэлт болгон хэрэглэхдээ жишин харьцуулж байгаа хоёр юмыг ямар нэг адил юм уу, төслүү шинжээр нь авалцуулан холбож (ассоциаци), улмаар адилсуулсны (аналоги) үр дүнд л сая адилтгал, адилтгасан нэрлэлт бий болно” (Шинэбаяр, Золжаргал, 2020: 40) гэжээ.

Машин, техникийн салбарт бичил эксковаторыг *авгалдай* (ZM12 мини экскаватор) гэдэг нь тун сонирхолтой юм. Энэ нь нийгмийн хөгжлийн явцад буй болсон шинэ эд юм, ухагдахууныг нэрлэх болсон хэрэгцээ шаардлагын улмаас үүсжээ. Эксковатор (55)-ыг *унагалдай* гэдэг тул түүнээс жижиг эксковаторыг хэлбэр төрх, овор хэмжээнд нь таацуулан, *авгалдай* гэж ёгтлон нэрлэжээ. “Монгол хэлний ижил үг өөр өөр утгатай ч хэлбэрээрээ ижилсдэг бол салаа утгат үг үүний эсрэгээр, нэг утгаас олон утга салбарлан хэлбэрээрээ ондооших хандлагатай байдаг. Энэ нь хэлний цөөн тэмдгээр олон утга санааг илтгэх буюу хэлний хэмнэх ёстой холбогдоно” (Идэрбаяр, 2005: 26). Утга зохиолын хэлний авгалдай гэдэг үгээр шинэ эд юм, ухагдахууныг илэрхийлж буй нь хэлний хэмнэх ёс юм. Тэрчлэн адилтгах, төлөөлөх сэтгэлгээ, бэлгэдэх ёс тэргүүтэн холбогдоно. Тухайлбал, шавж, аалз, эрвээхий тэргүүт амьтны хөгжлийн өндөгний дараах шатыг авгалдай (бүрэн бус хувиралд хүрэнцэр) гэдэг. Энэ үгээр газар ухах, малтах зориулалттай хамгийн бичил техникийг нэрлэж буй нь харьцангуй хийсвэржсэн ойлголт юм. “Хүн бодит орчинд амьдрахаас гадна бэлгэ тэмдгийн ертөнцөд амьдардаг. Тэрхүү бэлгэ тэмдгийн нэг нь хэл юм. Хэлийг хоёрдогч бэлгэдэл гэдэг. Бэлгэдэл нь соёл буюу сүегэр нэгжийн гол цөм нь болдог. Учир нь бэлгэ тэмдэг нь санаа (смысл, концепт)-аар баяжих төдийгүй, адилтгал төлөөлөлтэй ямагт холбоотой байдаг” (Базаррагчаа, 2003: 9). “Цас шиг цагаан, төмөр мэт хатуу гэх мэтээр шууд адилтгах нь зүйрлэл юм. Харин илэрхий дурдалгүй хоёр айг жишин харьцуулах нь адилтгал юм. Адилтгал гэдэг нь сурвалж болон зорилтот хүрээнээс хамаардаг” (Keith Brown, Jim Miller, 2013: 384). Иймд шавж нь сурвалж хүрээ, бичил техник нь зорилтот хүрээ юм. Хөрсний шавж нь хөрсийг задалж, сийрэгжүүлж, үржил шимийг сайжруулдаг. Энэ нь хөрсийг ухах малтах, бутлах зэрэг техникийн үйл ажиллагаатай ч давхар холбогдох тул эксковаторын ZM12-ыг авгалдай гэж ёгтлон нэрлэжээ. Ж.Баянсан “метафорыг хэрэглээний үүднээс ёгтолсон, егөөдсөн, амьдчилсан, амьтанчилсан утгатай гэх мэтээр зүйл болгон хэлэлцэх боломж бий. Бүтэж буй арга зарчим нь тэдгээрт адил байдаг шинжээр нь ийнхүү бүхэл багц болгон үзэх нь уг үзэгдлийн ерөнхий шинж, онцлогийг танихад дөхөмтэй байдаг” (Баянсан, 2022: 24) гэжээ. Иймд *амьжиргаа цагаан, чарга, аавын цээж, ээжийн бөгс* тэргүүтэн нь ёгтолсон утгатай бол *авгалдай, унагадай* нь амьтанчилсан утгатай. Ийнхүү адил төстэй шинж чанараар нь багцлан сэтгэж буй нь үндэсний танин мэдэхүйн хэв шинж юм. Түүнчлэн *авгалдай* гэдэг үг ч мөн адил бага оврын эксковатор; шавжийн хөгжлийн өндөгний дараах шат гэсэн онхи ондоо утгатай ижил үг мэт боловч хэлний бэлгэ тэмдгийн үүднээс холбоотой юм. Өөрөөр хэлбэл агуулгаараа ондоошиж, гаргалгаараа ижилсэх ёс юм.

Эксковаторын 210, 132, 55 гэх мэт хүчин чадлын хэмжээнээс хамааран бага оврын эксковатор (55)-ыг **унагалдай** гэдэг. Энэ нь унага + лдай² (-дай²) гэсэн бүтэцтэй бөгөөд авгалдай, хүүхэлдэй, бухандай, гургалдай, цуравдай зэрэг үгтэй адил зүй тогтлоор үүсжээ. Хэлний баримтад *унагалдай хадгаламж, унагалдай нэвтрүүлэг* гэх мэтээр тохиолдох ба орчин цагийн монгол хэлэнд үүссэн шинэ үг юм. Учир нь орчин цагийн монгол хэлний тайлбар толиудад *унагалдай* гэдэг үг тохиолдохгүй байна. Тус -лдай² -дай² дагаврын утгыг *хүүхэлдэй, бухандай, авгалдай, гургалдай, харалдай, боролдой, улаандай, хоохондой* зэрэг үгийн утга, бүтцээс харахад аливаа юмны шинж чанар, дүр байдлыг багасгасан, өхөөрдөл өнгө аястай юм.


хүүхэлдэй	(Mo. keüken+ldai)
бухандай	(Mo. buqan+dai)
гургуулдай	Mo. yuryuul+dai
авгалдай	*babayar+ldai *babayaldai > *abayaldai
харалдай	qara+ldai
боролдой	boru+ldai
улаандай	ulayan+dai

Бүдүүвч 1. Жинхэнэ нэр бүтээх -лдай² -дай² дагаварт үгийн бүтэц

Үүнд дурдсан гургуул, гургалдай гэдэг хоёр өөр шувууны нэр *гургуул* ~ *хяргуул* (Ma. ulhūma, Mo. yuryuul) → *гургалдай* (Ma. fenihe ulhūma, Mo. yuryuuldai) (Oliver Corf, 2013: 907) гэж үүсжээ.* Үүнд мөн бага жижиг гэсэн утга хадгалагдаж байна. *Хүүхэлдэй, бухандай, гургалдай* зэрэг үгийн зүй тогтлоос харахад унаганы дүр байдал, шинж төрхийг багасгах үндэслэлгүй юм. Учир нь *хургалдай, ботголдой, ишгэлдэй, тугалдай* гэж үүсэхгүй байна. Гэхдээ хэл зүйн идэвхтэй дүрэм бага давтамжтай дүрмээ өөртөө татан ижилсүүлэх ёсыг “аналоги” гэнэ. Цагийн явцад жинхэнэ зөв хэлбэр нь мартагдаад, аналоги нь дүрэм болж хэвших нь олонтоо (Саруул-Эрдэнэ, 2015: 107). Хамгийн түгээмэл

* Газар ухаж үүрээ барьдаг, бяцхан хошуутай хурц өнгөтэй, урт сүүлтэй, тахиатай төстэй, бие охор, жимс ургамлаар хооллодог шувууг гургуул; чийглэг газрын навчит ой, бут харганаар үүрлэн амьдардаг нүүдлийн шувуу, бие бага, байдал тагтааны адил, гайхамшигтай сайхан жиргэдэг шувууг гургалдай гэнэ.

хэрэглэдэг хэл зүйн хэлбэр нь хэл зүйн бус хэлбэрээ хувиргадаг. Тухайлбал, өвөг англи хэлний brethren “ах дүүс” хэмээх үг бусад олон тооны хэлбэрийн аналогийор brothers “ах дүүс” болж хувирчээ (Keith Brown, Jim Miller, 2013: 24). Иймд хүүхэлдэй, бухандай, гургалдай, авгалдай, хоохондой зэрэг үгийн аналогийор унагалдай гэж үүссэн байна. Гэхдээ унагалдай гэдгээс ч өмнө амьтны үр төлийн дүр байдал, шинж төрхийг багасгасан утгатай үг үүсэж байв. Тухайлбал, алтан цуравдай гэдэг үг энэхүү зүй тогтолд хамаарна. Учир нь *altan ċurbadai* = *ċurba* + (*yurγuuldai*) (Мижиддорж, 1976: 295) гэж үүссэн нь үүнийг батлах баримт юм. Энэхүү хураасан үгийн бүтцийг ажиглахад *Ma. gūlin cecike* *Mo. алтан гургалдай*, *Ma. deberen gūlin cecike* *Mo. алтан цуравдай* (Oliver Corf, 2013: 913) буюу “зулзага” (*Ma. deberen*) гэсэн үгийг танаж үүссэн байна. Энэ нь нийлэмж үгийн дундаас хураах (middle clipping) үзэгдэл юм. Хорин нэгт тайлбар тольд галуу, нугас, гургуулын зулзага **ихээхэн** болсныг цурав хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 1977: 785) гэж тайлбарласан байдаг. Харин алтан гургалдайн **нялх** зулзагыг *алтан цуравдай* гэдэг. Түүнчлэн *цурав* → *цуравдай* гэж үүссэн тул *унага* → *унагалдай* хэмээн үүсэж болох ажээ. Загварчлан үзүүлье.



Бүдүүвч 2. Жинхэнэ нэр бүтээх -лдай²-дай² дагаврын аналогийор үүссэн үгс

Гэхдээ унагалдай нь нялх унаганы өхөөрдөл бус машин техникийн ёгтолсон нэрлэлт болжээ. Учир нь эксковаторын овор хэмжээнээс хамааран, бага жижиг гэсэн өхөөрдөл утгыг илтгэж байна. Метафорыг хэрэглээний үүднээс ёгтолсон, егөөдсөн, амьдчилсан, амьтанчилсан утгатай гэх мэтээр зүйлчлэн үздэг тул *авгалдай*, *унагалдай* зэрэг нь адилтгалын аргаар үүссэн мэргэжлийн үг юм. Үүнд адуу бол хүч чадал гэсэн танихуйн зүйрлэл үүсэж байна. Учир нь таван хошуу малын дотроос хомбон туурайтай учир өдөр тутмын уналга эдэлгээнд хамгийн хөшүүрэгтэй нь адуу юм. Иймд эксковаторыг адуутай жишин адилтгах тул бага оврын эксковаторыг унагалдай хэмээн нэрлэжээ.

Г.Аким жолооч нарын яриан дахь *зүрх араа*, *хацар араа*, *ноён араа*, *цэцэг араа* гэсэн мэргэжлийн үгийг нэр томьёо болгон авч үзэх нь зүйтэй (Аким, 1986: 9) гэсэн бол Б.Содном ардын амьд яриан дахь *зүрх араа* гэдэг мэргэжлийн үгээр нэр томьёо оноох нь тун чухал (Шинэбаяр, 2024: 48) гэжээ. Мэргэжлийн хэлийг байгаж хэлний цогц гэж үзсэн нь үүнтэй шууд холбогдоно. Учир нь хүний хэл, амьд ярианы хэлэнд л мэргэжлийн үг үүсэх учиртай. Мөн *ул араа*, *туулай араа*, *мэлхий араа*, *хорхой араа* ~ *могой араа*, *галуун хүзүү*, *тахир гол*, *зөгий үүр*,

будаа шүүр, өндгөн тулгуур, таван бул зэрэг нийлмэл бүтэцтэй мэргэжлийн үгс адилтгалын аргаар үүссэн байна. Энэ нь тухайн ойлголтыг адил байдаг шинж чанараар нь багцлан сэтгэж буй хэрэг юм. Тухайлбал, ноён → удирдлага, цэцэг → дэрвэгэр жижиг, ул → суурь, туулай → хурдан, мэлхий → удаан, хацар → хажуу тал, зүрх → гол хөтлөгч, хорхой → уян, галуун хүзүү → тахир урт, тахир гол → махир гэсэн утгыг илтгэж байна. Хэлбэр төрх, дүр байдлын хувьд адил тул *зөгий* үүр, *будаа шүүр*, *өндгөн тулгуур*, *таван бул* зэрэг нэрлэлт бий болжээ. Мөн дан үгсийг авч үзвэл *тах* (чиргүүл холбогч), *эмээл* (чиргүүлийн суурь), *хэл* (эмээлийг хашиж барих хэл), *индүү* (road roller) зэрэг нь хэлбэр төрх, үйл хөдлөл адил тул утга шилжиж үүссэн байна. Газрын хуниасыг илж тэгшилж байгаа тул *индүү* (Road roller)-г *илүүр* (Mo. ileür, iligür), шанагадах зориулалттай тул ковшийг *шанага* гэж уугуул үгээр нэрлэвэл илүү оновчтой. Үүнд дурдсан *хорхой араа* гэдэг уламжлалт мэргэжлийн үгээр төрөлжүүлэн нэр томьёо оноосон байдаг.

архимедийн хорхой араа

архимедов червяк

хорхой араат бортголжин саалтуур

червячно-цилиндрический редуктор

хумих муруйт хорхой араа

эвольвентный червяк (Мижиддорж,

Баасанжав, 1988: 79-82).

Мөн *эмээл* (седёлка), *эмээл тээг* (фрикционная шпонка), *тахир гол* (каленчатый вал) (Мижиддорж, Баасанжав, 1988: 88, 64) зэрэг нэр томьёо бий. О.Шинэбаяр, Б.Золжаргал нар хүн, амьтан, эд юмсаас адилтгалын аргаар бүтсэн техник, технологийн нэр томьёог тухайлан тайлбарлажээ (2020: 73-76). Үүнд *хорхой араа*, *могой хоолой*, *эрвээхий эрэг*, *дээд шанага*, *араат бөгж* зэрэг мэргэжлийн үгс тохиолдоно. Энэ нь ардын амьд ярианы хэлэн дэх мэргэжлийн үгийг нэр томьёо болгон ашигласан туршлага юм. Өөрөөр хэлбэл утга зохиолын хэлний үг болон үгийн сангийн нэгжийг тусгай мэргэжлийн салбар юм уу оногдохуунд нэр томьёоны үүргээр хэрэглэх үйл явц буюу нэр томьёожих (terminologization) (Мөнхцэцэг ба бус, 2024: 43) үзэгдэл юм. Түүнчлэн *унагалдай* болон *авгалдайн* шанагыг *чимхүүр*, *халбага*, *шанага* хэмээн шатлан нэрлэжээ. Энэ нь овор хэмжээ, хэлбэр дүрснээс хамааран, адилтгалын аргаар үүссэн мэргэжлийн үг юм.

3.3. Хэлц үг, этгээд үг хэллэг

Ж.Төмөрцэрэн зарим нэр томьёо буюу нийлмэл үгийн зүйл өөрийн шинж чанараараа өвөрмөц хэлцтэй төстэй байдаг хэмээн *чонын элэг*, *усан шимэлдэг*, *алаг нохой*, *шар шувуу*, *хар сүүдэр*, *улаан нүдэн* (Төмөрцэрэн, 2023: 109) зэрэг жишээг дурдсан бол Г.Гэрэлмаа хөнгөн *цагаан* (алиминий), *хурдан цагаан* (колоколчих крупноцветный), *эргүү цагаан* (нэг настай тарвага) зэргээр тухайн юм



Зураг 3. Амьжиргаа цагаан
Эх сурвалж: <https://www.japancardirect.com/>

ухагдахууны дүр байдал, шинж чанарыг илтгэн хэвшин тогтсон нэр томьёог хэлц нэр томьёо (Гэрэлмаа, 2019: 44) гэсэн байдаг. Иймд *амьжиргаа цагаан, аавын цээж, нисдэг авс* зэрэг нь хэлц үгийн зүй тогтлоор үүсжээ. Тэрчлэн “амьжиргаа цагаан” гэдэг нь амьдрал, өдөр тутмын аж төрөлд амьжиргаа залгуулах хэрэгсэл гэдгээс утга шилжиж үүссэн бол аавын цээж (УАЗ) нь хэлцээс утга шилжсэн мэргэжлийн үг юм. Хэнхгэр, давлиун зантай хүүхдийг ёгтлох *аавын цээж* гэсэн хэлц үгээс овор хэмжээ жижиг ачааны машиныг нэрлэн утга шилжжээ.

Амьжиргаа цагаан нь ярианы хэлэнд *амьжиргаа, амиа* болж хэмнэгдсэн нь ч бий. Энэ нь *хорин дөрөв* (вольга 24), *гуч* (ЗИЛ 130), *гучин нэг* (ЗИЛ 131), *тавин гурав* (ГАЗ 53), *жаран дөрөв* (ЗИЛ 164), *жаран зургаа* (ГАЗ 66), *жаран долоо* (ГАЗ 67), *жаран ес* (УАЗ 469) хэмээн тооны нэрээр хураахтай адил юм.

Нисдэг авс, золбин шар, аавын цээж, ээжийн бөгс (араг үүрсэн чавганц), чарга (Porter, Bongo), *лааз ~ баттерей* (Pruis), *үнсний сав* (амьжиргаа цагаан) тэргүүтэн нь тухайн юм ухагдахууны онцлог шинж, үйл хөдлөл, дүр байлыг илтгэсэн хэлц үгийн шинж чанартай мэргэжлийн этгээд хэллэг (professional jargon) юм. Мөн этгээд үг хэллэг нь хэлц үг үүсэх нэг арга болдог (Самбуудорж, 2002: 37). О.Самбуудорж “этгээд үгийг бүдүүлэг үг хэллэг (арго), мэргэжлийн этгээд үг хэллэг (жаргон), нийтийн этгээд үг хэллэг (слен) гэж гурав ангилан, мэргэжлийн болон нийтийн этгээд үг хэллэг нь үгийн утга шилжүүлэх, харь үг зээлэх аргаар бүтэж байхад бүдүүлэг үг хэллэг нь ярианы хэлний үгийн сан, хэл зүйн дүрмийг голлон ашигладаг” (2002: 33) гэжээ. Ер нь мэргэжлийн үг этгээд үгийн хэлбэрээр үүсэх нь олонтоо. Мэргэжлийн хэлний үгийн санд мэргэжлийн ярианы үг, мэргэжлийн этгээд үг, мэргэжлийн албан үг багтана (Шинэбаяр, 2024: 16). Этгээд үг хэллэг нь үгийн утга шилжүүлэх, зүйрлэх, авиаг өөрчлөн дуудах зэргээр үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүнд түшиглэн бий болдог (Пүрэвжав, 2022: 217). Нийгмийн харилцаанд төдий л тохиолдохгүй, тусгай мэргэжил, бүлгийн хүрээнд харилцдаг үгс нь мэргэжлийн этгээд үг (жаргон) юм. Э.Пүрэвжав жолооч нарын, жүжигчдийн, наймаачдын, тамирчдын, хоригдлын, хулгайч нарын этгээд үг хэллэг гэхчлэн төрөлжүүлэн ангилж болно (2022: 217) гэсэн байдаг.

Этгээд үг хэллэг нь хэл ярианд тогтсон нэгэн хэвийн өнгө маяг, хэлбэр журмыг өөрчилж, хэл яриаг хөнгөн хөгжүүн болгох зорилготой (Баттөгс ба бус, 2022: 215) тул хоч нэртэй адил зүй тогтлоор үүсдэг. *Үнсний сав, лааз ~ баттерей, чарга, тавчик, ээжийн бөгс, араг үүрсэн чавганц* гэдэг нь хэлбэр төрх, шинж чанарыг нь доромжилсон өнгө аястай бол *аавын цээж, амьжиргаа цагаан* гэдэг нь утга шилжиж үүсжээ. *Нисдэг авс* гэдэгт “хурд”, “хайрцаг” гэсэн утга хадгалагдах бол *золбин шар* гэдэг нь хэрэн хэсэн тэнүүчлэх гэсэн утгатай юм. Этгээд үг хэллэгийг хэлний соёл, хэм хэмжээнд харш гэж үзэж болох ч тээврийн хэрэгсэл болон түүний эд ангийг хэлц үг, этгээд үг хэллэгээр илэрхийлэх нь харь хэлний үгээс сэргийлэх, хэлний уугуул үгээр товч, оновчтой, цомхон илэрхийлэх нэг арга юм.

Хэлний уугуул үгээс гадна *миксер* (Mixer), *лааз ~ баттерей* (Pruis), *тавчик* (Porter, Bongo), *шаахайт* (3 дугуйт) зэрэг харь үгээр нэрлэсэн байна. Харь үгээр нэрлэх нь мэргэжлийн этгээд үг үүсэх нэг арга билээ (Самбуудорж, 2002:

33). Мөн машины эд ангид *шалдан мотор* (дагалдах эд ангигүй мотор), *боовон гол* (хүнд машин механизмын толгой, чиргүүл хоёрыг холбогч) зэрэг этгээд үг тохиолдоно. *Тавчик, лааз ~ баттерей, шаахайт* зэрэг нь ёгтолж егөөдсөн доромж өнгө аястай. Харин *шалдан мотор* гэдэг нь дагалдах эд ангигүй нүцгэн гэсэн утга илтгэх бол *боовон гол* гэдэг нь эр бэлгэтэй жишиж үүссэн байна. “Монгол хэлний этгээд үг хэллэг бүдүүлэг, чамирхсан, хөгжүүн, басамжилсан, тохуурхсан, хошигносон утгатай” (Шагдарсүрэн ба бус, 2022: 112). *Үнсний сав, лааз, баттерей, тавчик, ээжийн бөгс, араг үүрсэн чавганц, нисдэг авс, золбин шар, чарга, боовон гол, шалдан мотор* зэрэг нь бүдүүлэг утгатай, *аавын цээж, авгалдай, унагалдай* зэрэг нь хөхиүн хөгжүүн утгатай ажээ. Мөн этгээд үг хэллэг нь урт насалдаггүй тул *араг үүрсэн чавганц, нисдэг авс, золбин шар, шаахайт* зэрэг нь техник, технологийн хөгжлийн явцад хэрэглээнээс гарч байна.

Дүгнэлт

Нэр томьёо болон мэргэжлийн үгс нь үгийн сангийн найрлага бүрэлдэхүүнд хамаарна. Нэр томьёо, мэргэжлийн үг хоёрыг ойролцоо утгын харьцаатай аль эсвэл мэргэжлийн үг нь нэр томьёо, хэлний үгийн сан хоёрын завсрын шинжтэй үгс хэмээн тодорхойлж иржээ. Нэр томьёо шинжлэх ухааны ойлголт, ухагдахууныг нэрлэн томьёолох бол мэргэжлийн үг өөрөө үүсэх, өөрөө бүрэлдэх зүй тогтолтой. Мэргэжлийн үгс нь аль нэг хөдөлмөрийн хуваарьтай холбогдон, тухай тухайн мэргэжлийн онцлогоос хамааран бий болдог. Түүнчлэн мэргэжлийн үг ардын амьд ярианы хэлэнд л тохиолдох бөгөөд байгаж хэлний цогц гэдэг нь үүнтэй холбогдоно. Тээврийн хэрэгслийн мэргэжлийн үг үүсэх арга, зүй тогтлын хувьд авиа зүйн болон адилтгалын аргаар, этгээд үг, хэлц үгийн хэв маягаар үүсэж байна. Машин, техникийн нэр томьёоны тухайд ардын амьд ярианы хэлэн дэх мэргэжлийн үгээр нэр томьёо оноосон туршлага бий. Иймд мэргэжлийн үг нь утга зохиолын хэлний үг болон нэр томьёо хоёрын завсрын шинжтэй юм. Тээврийн хэрэгслийн эд ангийн тухайд *зүрх араа, хацар араа, ноён араа, цэцэг араа, ул араа, туулай араа, мэлхий араа, хорхой араа* зэрэг мэргэжлийн үгээр нэр томьёо оноох нь тухайн ухагдахууныг оновчтой тодорхойлох, харь гаралтай нэр томьёог үгийн сан, утга зүйн аргаар дүйлгэн орчуулах зэрэг чухал ач холбогдолтой юм. Энэ нь адил байдаг шинж чанараар нь адилсуулан холбож байгаа үндэсний сэтгэлгээний онцлог, хэв шинж юм.

Тухайн ойлголт ухагдахууныг шинж чанар, дүр байдлаар нь илэрхийлсэн нэр томьёог хэлц нэр томьёо гэдэг. *Амьжиргаа цагаан, аавын цээж* зэрэг нь хэлц мэргэжлийн үг юм. Мөн *унагалдай, авгалдай* зэрэг нь сэтгэл хөдлөлийн болон ёгт өнгө аястай тул нэр томьёо бус мэргэжлийн үг юм. Мэргэжлийн үгэнд мэргэжлийн албан үг болон этгээд үг хэллэг багтдаг. *Лааз ~ баттерей* (Pruis), *тавчик* (Porter, Bongo), *шаахайт* (3 дугуйт), *араг үүрсэн чавганц, нисдэг авс, золбин шар, пад пад, чарга* (Probox), *боовон гол, шалдан мотор* зэрэг этгээд үг нь мэргэжлийн хэлийг хөхиүн хөгжүүн өнгө аястай болгодог ажээ. Ийнхүү этгээд үгээр нэрлэх нь харь хэлний үгийг уугуул үгээр илэрхийлэх нэг арга юм.

Ном зүй

- Oliver Corf.** (2013). *Auf kaiserlichen Befehl erstelltes Wörterbuch des*. Wiesbaden: Harrasowitz Verlag.
- Keith Brown, Jim Miller.** (2013). *The Cambridge Dictionary of Linguistics*. New York: Cambridge University Press.
- Аким, Г.** (1986). Нэр томъёо орчуулах асуудалд. *Орчуулах эрдэм* 4: 3-9. [On the Issues of Term Translation]. *Orchuulah erdem, Ulsyn hewleliin gazar*. 1986, 4: 3-9.]
- Базаррагчаа, М.** (2003). *Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр. [Bazarragchaa, M. *Mongol helnii süeyeger ba nairuulbariin tuhai* [About the Mongolian Culture and Stylistics]. Ulaanbaatar: Num Press. 2003.]
- Баттөгс, Ш., Пүрэвжав, Э. Түвшинтөгс, Б., Гэрэлмаа, Г., Шинэбаяр, О., Ганболд, Д.** (2022). *Үгийн сан, утга, найруулга судлал*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй. [Battögs, Sh., Pürevjav, E., Tüvshintögs, B., Gerelmaa, G., Shinebayr, O. Ganbold, D. *Ügiin san, utga, nairuulga sudlal* [Lexicology, Semantics, Stylistics]. Ulaanbaatar. 2022.]
- Батчулуун, Д.** (2016). *Хэл шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Batchuluun, D. *Hel shinjleliin udirtgal* [Introductions to Linguistics]. Ulaanbaatar: Soyombo Press. 2016.]
- Баянсан, Ж.** (2022). Биеэр амилмал утга санаа буюу метафор. *Хэл шинжлэл, хэлний соёл судлал*, 24-29. [Metaphor Realized Meaning]. *Hel shinjlel, helnii soyol sudlal, Ulaanbaatar: Linograph*. 2022, 24-29.]
- Гэрэлмаа, Г.** (2019). Өнгө заасан үгтэй нийлмэл болон хэлц нэр томъёо. *Хэл зохиол судлал* 44. Улаанбаатар: Соёмбо принтинг, 41-51. [Compound and Phrasal Terms Denoting Colours]. *Hel zohiol sudlal*, 44. Ulaanbaatar: *Soyombo Press*. 2019, 41-51.]
- Догсүрэн, Ч.** (1988). *Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр. [Dogsüren, Ch. *Mongol ner tomiyo onookh, tolikokh, jigdlekh asuudald* [On the Issues of Creating, Processing, Harmonizing Mongolian Terms]. Ulaanbaatar: Printing of Mongolian Academia of Science. 1988.]
- Зээнямбуу, Ч., Базаррагчаа, М.** (2014). *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар: Бит пресс. [Zeenyambuu, Ch., Bazarragchaa, M. *Hel shinjleliin ner tomiyonii tailbar toli* [Glossary of Linguistic Terms]. Ulaanbaatar: Bit Press. 2014.]
- Идэрбаяр, Б.** (2005). *Монгол хэлний төсөөт үг*. Улаанбаатар: Төмөр замын хэвлэх үйлдвэр. [Iderbayar, B. *Mongol helnii töсөөт үг* [Mongolian Paronym]. Ulaanbaatar: Printing of Railroad. 2005.]
- Мижиддорж, Г.** (1976). *Монгол, манж бичгийн хэлний харьцаа*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл. [Mijiddorj, G. *Mongol, manj bichgiin helnii haritsaa* [Relation of Mongolian and Manchu Written Languages]. Ulaanbaatar: Printing of Mongolian Academia of Science. 1976.]

- Мижиддорж, Г., Баасанжав, Р.** (1988). *В.В.Шварц машин техникийн зурагт орос англи монгол товч толь УНТКМ № 140-143*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй. [Mijiddorj, G., Baasanjav, R. *Shwartz V.V mashin technikiin zuragt oros, angli, mongol tovch toli*. [Illustrated Dictionary of Machine and Technique in English, Russian and Mongolian by Shwartz V.V]. Ulaanbaatar: Hevleliin gazar ügüi. 1988.]
- Мөнхцэцэг, Н., Амартүвшин, Н., Гэндэнпил, Х., Шинэбаяр, О., Гэрэлмаа, Г., Золжаргал, Б.** (2024). *Нэр томьёо судлалын толь бичиг*. Улаанбаатар: Бит пресс. [Münkhtsetseg, N., Amartüvshin, N., Gendenpil, Kh., Shinebayar, O., Gerelmaa, G., Zoljargal, B. *Ner tomiyo sudlaliin toli bichig* [Terminology of Terminology]. Ulaanbaatar: Bit Press. 2024.]
- Надмид, Ж., Өнөрбаян, Ц.** (2023). Шинжлэх ухааны нэр томьёог хэл шинжлэлийн үүднээс зөв тогтоох тухай асуудалд. Өнөрбаян, Ц. *Монгол хэл бичгийн судлал, сургалт* (158-166). Улаанбаатар: Соёмбо принтинг. [Nadmid, J., Önörbayan, Ts. *Shinjeleh uhaanii ner tomiyog hel shinjeleliin үүдnees zöv togtooh tuhai asuudald* [On the Issues of Creating Scientific Terms from the Aspect of Linguistics] Önörbayan, Ts. *Mongol hel bichgiin sudlal, surgalt*. Ulaanbaatar: Soyombo Printing. 2023.]
- Самбуудорж, О. Эрдэнэсүвд, Л.** (2002). *Монгол хэлний этгээд үг хэллэг этгээд үг хэллэгийн товч толь*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй. [Sambuudorj, O., Erdenesuvd, L. *Mongol helnii etgeed üg helleg etgeed üg hellegiin tovch toli* [Brief Dictionary of Jargons and Mongolian Jargons]. Ulaanbaatar: Hevleliin gazar ügüi. 2002.]
- Саруул-Эрдэнэ, М.** (2015). *Зугаатай хэл шинжлэл*. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Saruul-Erdene, M. *Zugaatai hel shinjelel* [Amusing Linguistics]. Ulaanbaatar: Mönhiin üseg. 2015.]
- Төмөртоого, Д.** (2004). *Хэл шинжлэлийн нэр томьёоны хураангуй толь*. Улаанбаатар: Адмон. [Tümürtogoo, D. *Hel shinjeleliin ner tomiyonii huraangui toli* [A Concise Dictionary of Linguistics]. Ulaanbaatar: Admon. 2004.]
- Төмөрцэрэн, Ж.** (2023). *Монгол хэлний үгийн сан судлал*. Улаанбаатар: Мон эдү пресс. [Tömörtseren, J. *Mongol helnii ügiin san sudlal* [Mongolian Lexicology]. Ulaanbaatar: Mon Edu Press. 2023.]
- Хорин нэгт тайлбар толь.** (1977). ОМАНН. [Khorin negt tayilbar toli [Glossary of Twenty One Volume]. ОМАНН. 1977.]
- Шинэбаяр, О.** (2024). *Нийгмийн аялгуу судлал*. Улаанбаатар: Битпресс. [Shinebayar, O. *Niigmiin ayalguu sudlal* [Social Dialectology]. Ulaanbaatar: Bit Press. 2024.]
- Шинэбаяр, О., Золжаргал, Б.** (2020). *Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Shinebayar, O., Zoljargal, B. *Adiltgaliin argaar butsen mongol ner tomiyo* [Mongolian Terms Created by Metaphorical Method]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2020.]